



**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**



Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	8
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар	9
2.8.3	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	11
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	11
2.11	Шилэн дансны мэдээлэл	12
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	12
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3	Менежментийн захидал	13
3.1	Зардлын данстай холбоотой асуудал	13
3.2	Балансын данстай холбоотой асуудал	13
3.3	Балансын данстай холбоотой асуудал	14
3.4	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал	14
3.5	Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжтай холбоотой асуудал.....	14
3.6	Дотоод хяналттай холбоотой асуудал	15
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
4.1	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	16
4.2	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	17
4.3	Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.4	Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	19
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	20
5	Хавсралт	22
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГА Г.ГАНТӨМӨР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019. 03. 25 № 01/567
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Стандарт, хэмжил зүйн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Стандарт, хэмжил зүйн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Стандарт, хэмжил зүйн газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Аудитын гол асуудал

Стандарт, хэмжил зүйн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшингээс давсан нь “Хязгаарлалттай санал дүгнэлт” өгөх үндэслэл болно. Үүнд:

- Жилийн эцэст 299.4 сая төгрөгийн бараа материалын, 156.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлд эд хөрөнгийн тооллого хийгээгүй, үндсэн хөрөнгийн тооллогыг чанаргүй гүйцэтгэсэн, тооцоо бодоогүй;
- Эд хөрөнгийн тооллогоор 14 төрлийн 5.8 сая төгрөгийн бараа материал, 7 нэр төрлийн 5.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө дутагдсан;
- Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 25.8 сая төгрөгийн гүйлгээ хийж нягтлан бодох бүртгэлд тусгасан, худалдан авсан 26.4 сая төгрөгийн хөрөнгийг шууд зардлаар бүртгэсэн;
- Батлагдсан төсвөөс 21.3 сая төгрөгийг үрэлгэн, зориулалтыг зөрчин зарцуулсан; зэрэг нь эрх ба үүрэг, оршин байх, үнэн зөв байдал, иж бүрэн байх, тохиолдсон байх, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтууд, Сангийн сайдын 2006 оны 388 тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар”-ыг тус тус зөрчиж байна.

Үүрэг хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНБИЛЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Стандарт, хэмжил зүйн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Г.Гантөмөр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасаншийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Стандарт, хэмжил зүйн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Стандарт, хэмжил зүйн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 3 дугаар сарын 5-наас 2019 оны 3 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын ахлах аудитор Д.Энхдалай гүйцэтгэв.

Стандарт хэмжил зүйн газар 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 04/0193 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Стандарт хэмжил зүйн газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Стандарт, хэмжил зүйн газар нь “Монгол Улсын хөгжлийн стратеги чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж, экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлогоор дэмжлэг үзүүлэхэд оршино.” гэсэн эрхэм зорилго тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Монгол Улсын Шадар сайдын тушаалаар батлагдсан “Үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т Стандарт, хэмжил зүйн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх, зохицуулалтыг хангах, гадаад харилцаа, хамтын ажиллагааг эрхэлсэн асуудлаараа олон улс, бүс нутаг, гадаад орны хүрээнд өргөжүүлэх;
- Стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хууль тогтоомжийг боловсронгуй болгоход санал боловсруулах, бодлого стратегийг төлөвлөх, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах, гүйцэтгэлд хяналт- шинжилгээ үнэлгээ хийх;
- Стандартчилал, тохирлын үнэлгээ, техникийн зохицуулалтын хөтөлбөр, төсөл боловсруулах, техникийн зохицуулалтыг олон улсын жишгээр бий болгоход дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн төсөлд шүүлт хийх, эдгээр чиглэлийн дүрэм журам, заавар, удирдамжаар хангах;
- Хэмжлийн нэгжийн олон улсын системд тулгуурласан үндэсний эталоны тогтолцоог хөгжүүлэх, нарийвчлалыг олон улсын түвшинд

ойртуулах, үндэсний эталоноос нэгж дамжуулах тогтолцоог сайжруулан бэхжүүлэх;

- Итгэмжлэлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулалтыг хангах, олон улсын итгэмжлэлийн байгууллагаар итгэмжлүүлэх;
- Сорьцын хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, сорьцын лабораторийн чадавхыг дээшлүүлэх;
- Олон улсын гэрээ, хэлэлцээр, олон улс, бүс нутаг, гадаад орны болон үндэсний стандарт, тохирлын үнэлгээ, техникийн зохицуулалт болон холбогдох норматив-техникийн баримт бичгээс бүрдсэн үндэсний мэдээллийн сан бүхий төрийн мэдээллийн нөөц болох албыг байгуулан хөгжүүлэх;
- Бүтээгдэхүүн, үйлчилгээ, тогтолцооны баталгаажуулалтыг олон улсын жишигт хүргэж хөгжүүлэх;
- Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтыг улсын баталгаажуулалтад заавал хамрагдах хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын түвшинг дээшлүүлэх, баталгаажуулалтын ажлын чанарыг олон улсын түвшинд ойртуулах;
- Хэмжих хэрэгслийн шалгалт, тохируулгын ажлын чанарыг зах зээлд хүртээмжтэйгээр олон улсын түвшинд хүргэх;

Стандарт, хэмжил зүйн газрын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль;
- Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль;
- Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай хууль;

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Стандарт, хэмжил зүйн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Стандарт, хэмжил зүйн газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүйгэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Стандарт, хэмжил зүйн газар санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Интерактив Би Ай ХХК-ийн “Эмералд” програм хангамжийг ашигладаг байна.

Стандарт, хэмжил зүйн газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

Стандарт, хэмжил зүйн газрын дотоод аудитын алба нь харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Стандарт, хэмжил зүйн газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 19 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 19 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг Стандарт, хэмжил зүйн газрын 2017 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 9,551.5 сая төгрөгийн 2 хувиар тооцон, материаллаг байдлын түвшинг урьдчилсан байдлаар 191.0 сая төгрөгөөр тогтоосон.



Гүйцэтгэлийн шатанд 2018 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 11,056.2 сая төгрөгийн 2 хувиар тооцон, материаллаг байдлын түвшинг 221.1 сая төгрөгөөр тогтоолоо.

Байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн нэгтгэсэн тайлан, балансын дансанд хийсэн эрсдэлийн үнэлгээг үндэслэн материаллаг байдлын түвшинг суурь үзүүлэлтээс 2 хувиар тооцсон.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний 21 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 17 байгууллага аудитад хамрагдсан, 4 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	17	0	4	0
Дүн		17	0	4	0

Аудитаар 15 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 1 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 1 санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгсөн.

2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Стандарт, хэмжил зүйн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 6,872.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 90.3 хувь буюу 6,202.7 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 0.3 хувь буюу 21.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 7.5 хувь буюу 513.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 1.7 хувь буюу 114.2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлж, 0.3 хувь буюу 20.6 сая төгрөгийн 3 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.

Аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 1.2 сая, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн нэгтгэлээр 6,201.5 сая төгрөгийн алдааг залруулсан болно.

Стандарт, хэмжил зүйн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

(сая төгрөг)

Байгууллагын ангилал	Залруулагүй алдаа, зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТШЗ	44	270.0	13	19.6	14	200.8	14	29.0	4	0	3	20.6
ТТЗ	12	399.7	2	1.8	5	312.6	5	85.3				
Дүн	56	669.7	15	21.3	19	513.4	19	114.2	0	0	3	20.6

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Стандарт, хэмжил зүйн газрын харьяа 20 аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн санхүүгийн тайланд аудит хийхээс 4 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 16 төсвийн захирагчийн санхүүгийн тайланд аудит хийсэн. Үүнээс 14 төсвийн захирагчийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй санал дүгнэлт” Говь-Алтай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн тайланд “Сөрөг санал дүгнэлт”, Ховд аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн тайланд “Хязгаарлалттай санал дүгнэлт” өгсөн.

Харьяа байгууллагуудын 2018 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 271.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 0.4 хувь буюу 1.2 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 7.2 хувь буюу 19.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 74.1 хувь буюу 200.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 10.7 хувь буюу 29.0 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлж, 7.6 хувь буюу 20.6 сая төгрөгийн 3 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.

Аудитаар зөрчил, нягтлан бодох бүртгэл, тайлагнал, хууль, журмын хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчлүүдэд 14 зөвлөмж өгсөн. Төсвийн захирагч нар зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

2.8.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр 19 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 14 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд тусгаж, бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1: Балансын данстай холбоотой асуудал

Жилийн эцсийн тооллогын комиссын бүрэлдэхүүнд ерөнхий нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогчийг оруулж тушаал гаргасан, үндсэн хөрөнгийн тооллогыг чанаргүй гүйцэтгэсэн, тооцоо хийгээгүй, баримтын бүрдэл дутуу, 287.5 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй, тооцоо бодоогүй нь үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцээгүй, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 70 дугаар зүйлийн 2 дахь *“Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана.” 1/ үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/; 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/;* заалтыг тус тус зөрчиж байна.

Шийдэл: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн;

Асуудал 2: Зардлын данстай холбоотой асуудал

Ажилтануудад цалинтай давхардуулан 1.6 сая төгрөгийн орчуулгын хөлс тооцож олгосон нь нь үнэн, зөв байдал толилуулга ба тодруулга батламж мэдэгдэлүүд болон Сангийн сайдын 2006 оны 388 тушаалаар батлагдсан *“Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар”-ыг тус тус зөрчсөн* байна.

Шийдэл: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн;

Асуудал 3: Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Төсвийг зохистой удирдаагүйгээс тайлант онд 2.9 сая төгрөгийн авлага, 8.4 сая төгрөгийн өр, төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хууль 6 дугаар зүйлийн 6.4.8. дахь *“төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”* заалтыг зөрчсөн;

Шийдэл: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн;

Асуудал 4: Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн зардлаас 12.2 сая төгрөгийг зориулалтыг зөрчин төвлөрсөн арга хэмжээнд зарцуулсан нь Төсвийн тухай хууль 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах,”* заалтыг зөрчсөн;

Шийдэл: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн;

Асуудал 5: Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Төвлөрсөн арга хэмжээнд 0.4 сая төгрөгийн анхан шатны баримтгүй ажил гүйлгээг төсвийн зориулалт зөрчин гаргасан нь Төсвийн тухай хууль 16 дугаар зүйл 16.5.5 дахь *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах,”* заалтыг зөрчсөн;

Шийдэл: Төлбөрийн акт тогтоосон;

Асуудал 6: Орлогын данстай холбоотой асуудал

Бусдаар гүйцэтгүүлсэн бараа, ажил, үйлчилгээний төлбөрөөс 1.4 сая төгрөгийн ХХОАТ суутган тооцож төсөвт төвлөрүүлээгүй нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2. дахь "хувиараа ажил гүйцэтгэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, үйлчилгээ үзүүлэх зэргээр олсон үйлдвэрлэл, арилжааны орлого", 23 дугаар зүйлийн 23.2.4."энэ хуулийн 18, 19 дүгээр зүйл, ... заасан орлогын дүнд 23.2.4-т заасан хувиар тус тус албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;" заалтыг зөрчиж байна.

Шийдэл: Төлбөрийн акт тогтоосон;

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулах, дотоод хяналт, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Тухайлбал:

- Ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулаагүй, хөрөнгийг данс бүртгэлд зөв ангилан бүртгээгүй, эд хөрөнгийн тооллогыг хугацаанд нь чанартай сайн хийдэггүй зэрэг нь санхүүгийн үйл ажиллагаанд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна.
- Програм хангамжаар бэлтгэсэн санхүүгийн тайлан, тодруулга нь Сангийн сайдын баталсан журам, зааварт нийцэхгүй байна.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Стандарт, хэмжил зүйн газарт 1 хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан зарцуулах 6,193.0 сая төгрөгийн төсвийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,486.0 сая төгрөг бүрдүүлэх төлөвлөгөөтэйгээс гүйцэтгэлээр 4,611.0 сая орлого бүрдүүлж 85.5 хувиар давуулан бүрдүүлжээ.

Зардлын нийт гүйцэтгэл 6,170.3 сая төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 4.0 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 9.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 9.5 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалжээ. Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 22.7 сая төгрөгийг төсвийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд оны эхэнд 4.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба Шинжлэх ухаан технологийн сангаас 14.0 сая, үйл ажиллагааны орлогоос

117.4 сая, орон нутгийн Засаг даргын нөөц сангаас 93.7 сая төгрөг нийт 225.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 181.3 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж 43.1 сая төгрөгийг төвлөрүүлж оны эцэст 5.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Стандарт, хэмжил зүйн газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр зэрэг мэдээллийг 8 удаа хугацаа хоцроон шилэн дансны нэгдсэн мэдээллийн цахим хуудсанд байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 5 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 3 зөвлөмж хэрэгжих шатанд, нийт 79.7 хувийн биелэлттэй байна. Тухайлбал:

Бүрэн хэрэгжээгүй 3 зөвлөмжөөс туслах үйл ажиллагааны орлогыг төсвийн тодотголоор оруулан батлуулахаар санал хүргүүлсэн, 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан 119.4 сая төгрөгийн баталгаажуулалтын авлагаас 85.8 хувь буюу 102.4 сая төгрөгийн авлага, 89.1 сая төгрөгийн өглөгөөс 92.8 хувь буюу 82.7 сая төгрөгийг барагдуулсан байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримтаар баталгаажуулж, гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Стандарт, хэмжил зүйн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчлийг эс тооцвол 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна. “Хязгаарлалттай санал дүгнэлт” өгөх үндэслэлийг Аудитын гэрчилгээний аудитын гол асуудал хэсэгт тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээ сурган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Стандарт, хэмжил зүйн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Анхан шатны бүрдэл дутуу 21.6 сая төгрөгийн баримтаар гүйлгээ хийсэн нь оршин байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” заалтыг зөрчсөн;

3.1.2 Эрсдэл: Холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгахгүй байх;

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана;

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Худалдан авсан 26.4 сая төгрөгийн хөрөнгийг шууд зардлаар бүртгэсэн нь үнэн, зөв байдал, толилуулга ба тодруулга батламж мэдэгдэлүүд болон Сангийн сайдын 2006 оны 388 тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл: Хөрөнгө, зардлыг зөв ангилан бүртгэж, тайлагнаагүй байх;

3.2.3 Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана;

3.3 Балансын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Кассын тайланд жижиг мөнгөн сангийн 29.8 сая төгрөгийн гүйлгээг дутуу тайлагнасан нь үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга батламж мэдэгдэлүүд болон Сангийн сайдын 2006 оны 388 тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан, тодруулгын холбогдох заавар, журмын дагуу бэлтгэж тайлагнаагүй байх;

3.3.3 Өгсөн зөвлөмж: Кассын тайланг холбогдох заавар, журмын дагуу бэлтгэж тайлагнаж байх;

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана;

3.4 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Ойн арга хэмжээнд зориулж 7,500.0 мянган төгрөгөөр баримтат кино хийлгэж төсвийг үрэлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3 дахь “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;”, 41.2.7. дахь “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах.”, заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.4.2 Эрсдэл: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх;

3.4.3 Өгсөн зөвлөмж: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зориулалтын зарцуулж байх;

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана;

3.5 Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжтай холбоотой асуудал

3.5.1 Илрүүлэлт:

Сангийн сайдын 2006 оны 388 тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар”-т нийцсэн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгээгүй, журнал, бусад мэдээллийг ирүүлээгүй нь үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга батламж мэдэгдэлүүдтэй нийцэхгүй байна.

3.5.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан, тодруулгын холбогдох заавар, журмын дагуу бэлтгэж тайлагнаагүй байх;

3.5.3 Өгсөн зөвлөмж: Програм хангамжийн сайжруулалт хийх, санхүүгийн тайлан, тодруулга, нягтлан бодох бүртгэл, анхан шатны бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу үнэн, зөв бэлтгэж тайлагнаж байх;

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана;

3.6 Дотоод хяналттай холбоотой асуудал

3.6.1 Илрүүлэлт:

Харьяа байгууллагуудад эд хөрөнгийн тооллого хийгээгүй, үндсэн хөрөнгийн тооллогыг чанаргүй гүйцэтгэсэн, тооцоо бодоогүй, хөрөнгө дутагдсан, анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж бүртгэлд тусгасан, төсвийг зориулалт бус, үрэлгэн зарцуулдаг зэрэг зөрчил, дутагдал гарч байна. Орон нутаг дахь салбар байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар Говь-Алтай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн тайланд “Сөрөг”, Ховд аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

3.6.2 Эрсдэл: Дотоод хяналтыг үр нөлөөгүй хэрэгжүүлснээс санхүүгийн үйл ажиллагаанд зөрчил, дутагдал гарах;

3.6.3 Өгсөн зөвлөмж: Салбар нэгжүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах;

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	443,234.1	907,133.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,424.5	5,147.7
33	АВЛАГА	119,475.9	148,724.7
34	УРЬДЧИЛГАА	42,000.0	-
35	БАРАА МАТЕРИАЛ	277,289.7	746,986.7
36	НӨӨЦИЙН БАРАА	44.0	6,274.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,966,605.4	5,763,473.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,966,605.4	5,763,473.4
392	Биет хөрөнгө	4,964,427.1	5,331,727.1
393	Биет бус хөрөнгө	2,178.3	431,746.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,409,839.5	6,670,606.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	96,082.8	18,111.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	96,082.8	18,111.3
413	Өглөг	95,018.8	17,455.8
414	Урьдчилж орсон орлого	1,064.0	655.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,313,756.7	6,652,495.2
51	Засгийн газрын хувь оролцоо	5,313,756.7	6,652,495.2
512	Хуримтлагдсан үр дүн	(1,760,826.9)	(1,587,044.9)
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,342,200.4	2,058,608.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,409,839.5	6,670,606.5

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,723,329.9	11,228,677.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,443,054.8	4,811,306.9
120	Нийтлэг татварын бус орлого	4,443,054.8	4,811,306.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,280,275.1	6,417,370.7
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,170,489.9	6,193,009.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	109,785.1	224,360.8
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	10,285,266.7	10,944,111.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,285,266.7	10,944,111.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,544,193.0	5,912,896.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,393,711.0	3,451,648.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	373,583.0	411,070.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	279,899.6	324,030.6
2104	Хангамж, бараа материалын зардал	173,088.3	226,793.0
2105	Нормативт зардал	49,381.3	108,352.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,838.4	255,904.4
2107	Томилолт, зочны зардал	146,631.4	191,144.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	188,794.2	154,340.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	905,265.8	789,612.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,741,073.7	5,031,215.6
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(561,936.8)	284,565.7
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	65.0
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,836.6	112,110.0
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(8,836.6)	(112,045.0)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(570,773.5)	172,520.8

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	9,549,402.7	11,029,735.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,496,530.6	4,611,459.0
120	Нийтлэг татварын бус орлого	3,496,530.6	4,611,459.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,052,872.1	6,418,276.6
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,170,489.9	6,193,009.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	109,785.1	225,204.8
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	742,612.7	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	29,984.4	61.9
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	9,513,375.7	10,539,248.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,513,375.7	10,539,248.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,725,641.6	5,431,002.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,362,039.5	3,447,413.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	368,356.2	415,877.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	283,749.3	344,176.0
2104	Хангамж, бараа материалын зардал	161,887.9	209,493.2
2105	Нормативт зардал	49,855.2	129,991.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	73,514.5	303,334.3
2107	Томилолт, зочны зардал	144,565.1	201,231.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	187,455.4	204,567.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,787,734.1	5,108,246.9
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	161,759.1	4,651,581.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	407,592.4	168,682.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,218,382.6	287,983.8
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	36,027.0	490,486.7
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	36,815.7	489,763.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	36,815.7	489,763.5
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(36,815.7)	(489,763.5)
1	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(788.7)	723.2
12	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,213.1	4,424.5
120	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,424.5	5,147.7

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,732,645.4	1,342,434.2	(1,198,639.2)	5,876,440.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(262.1)	(233.8)	8,585.8	8,089.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,732,383.2	1,342,200.4	(1,190,053.5)	5,884,530.2
Тайлант үеийн үр дүн	-	-	(570,773.5)	(570,773.5)
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,732,383.2	1,342,200.4	(1,760,826.9)	5,313,756.7
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,732,383.2	1,342,200.4	(1,760,826.9)	5,313,756.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,261.3	1,261.3
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,732,383.2	1,342,200.4	(1,759,565.6)	5,315,018.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	683,021.4	-	683,021.4
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	448,548.4	33,386.6	-	481,935.0
Тайлант үеийн үр дүн	-	-	172,520.8	172,520.8
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,180,931.6	2,058,608.4	(1,587,044.9)	6,652,495.2

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,193,010.3	6,170,329.2	22,681.1	99.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,847,010.3	5,824,329.5	22,680.8	99.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,450,676.8	5,429,610.4	21,066.4	99.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,450,527.6	3,446,551.3	3,976.3	99.9
210101	Үндсэн цалин	2,537,397.9	2,579,435.2	(42,037.3)	101.7
210102	Нэмэгдэл	515,586.3	487,974.1	27,612.2	94.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	192,076.2	192,560.0	(483.8)	100.3
210105	Гэрээт ажлын хөлс	205,467.2	186,582.0	18,885.2	90.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	416,255.3	415,679.8	575.5	99.9
210201	Тэтгэврийн даатгал	277,848.8	282,935.5	(5,086.7)	101.8
210202	Тэтгэмжийн даатгал	33,361.6	33,267.4	94.2	99.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	28,921.6	27,801.9	1,119.7	96.1
210204	Ажилгүйдлийн даатгал	6,920.3	6,616.6	303.7	95.6
210205	Эрүүл мэндийн даатгал	69,203.0	65,058.4	4,144.6	94.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	352,495.3	343,302.2	9,193.1	97.4
210301	Гэрэл, цахилгаан	87,565.5	89,661.0	(2,095.5)	102.4
210302	Түлш, халаалт	175,199.8	168,877.8	6,322.0	96.4
210303	Цэвэр, бохир ус	28,906.5	27,235.7	1,670.8	94.2
210304	Байрны түрээс	60,823.5	57,527.6	3,295.9	94.6
2104	Хангамж, бараа материалын зардал	210,172.2	208,785.7	1,386.5	99.3
210401	Бичиг хэрэг	44,003.2	43,294.5	708.7	98.4
210402	Тээвэр, шатахуун	93,116.4	93,474.6	(358.2)	100.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	38,969.3	36,886.1	2,083.2	94.7
210404	Ном, хэвлэл	100.0	78.4	21.6	78.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,829.0	4,303.2	1,525.8	73.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,154.3	30,748.9	(2,594.6)	109.2
2105	Нормативт зардал	132,784.2	132,765.2	19.0	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	125,893.2	126,032.7	(139.5)	100.1
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,891.0	6,732.5	158.5	97.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	333,244.6	333,400.9	(156.3)	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	41,038.0	43,057.9	(2,019.9)	104.9
210602	Тавилга	12,900.0	12,900.0	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	26,096.0	25,551.6	544.4	97.9
210604	Урсгал засвар	253,210.6	251,891.4	1,319.2	99.5
2107	Томилолт, зочны зардал	177,751.4	181,707.0	(3,955.6)	102.2
210702	Дотоод албан томилолт	177,751.4	181,707.0	(3,955.6)	102.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	208,789.1	199,533.6	9,255.5	95.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	88,426.7	83,224.8	5,201.9	94.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,872.0	3,182.0	690.0	82.2
210803	Даатгалын үйлчилгээ	5,158.9	4,591.8	567.1	89.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,344.3	2,036.9	307.4	86.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	466.6	384.3	82.3	82.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,154.0	3,338.6	815.4	80.4
210807	Газрын төлбөр	2,099.6	1,668.6	431.0	79.5
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,060.0	614.7	445.3	58.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	101,207.0	100,491.7	715.3	99.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	168,657.1	167,884.8	772.3	99.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	102,290.2	102,086.3	203.9	99.8



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН 2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ЖИЛИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	66,366.9	65,798.5	568.4	99.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	396,333.5	394,719.1	1,614.4	99.6
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	262,536.9	262,433.8	103.1	100.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	262,536.9	262,433.8	103.1	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	133,796.6	132,285.3	1,511.3	98.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	133,796.6	132,285.3	1,511.3	98.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	346,000.0	345,999.6	0.4	100.0
2200	Дотоод эх үүсвэрээр	346,000.0	345,999.6	0.4	100.0
220001	Барилга байгууламж	346,000.0	345,999.6	0.4	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,193,010.3	6,170,310.9	22,699.4	99.6
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,193,010.3	6,170,310.9	22,699.4	99.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	6,193,010.3	6,170,310.9	22,699.4	99.6
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	18.3	(18.3)	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	21	21	0	100.0
610001	Төсвийн байгууллага	21	21	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	383	383	0	100.0
620001	Удирдах ажилтан	29	29	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	233	235	-2	100.9
620003	Үйлчлэх ажилтан	67	71	-4	106.0
620004	Гэрээт ажилтан	54	48	6	88.9

5 Хавсралт

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Стандарт, хэмжил зүйн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудит	Аудитын код:	САГ-2019/5/СТА-ТТ3
2019.03.25				
Шалгагдсан байгууллагын нэр:	Стандарт, хэмжил зүйн газар		сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
A	3	4	5			9	10
1	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ, худалдан авсан бараа материалын үнээс 1.4 сая төгрөгийн ХХОАТ суутган тооцож төсөвт төвлөрүүлээгүй.	1.4	Төлбөрийн акт тогтоох			Дарга Нягтлан бодогч	Г.Гантөмөр, Б.Гантулга
2	Кассын тайланд жижиг мөнгөн сангийн 29.8 сая төгрөгийн гүйлгээг дутуу тайлагнасан.	29.8	Зөвлөмж өгөх.			Дарга Нягтлан бодогч	Г.Гантөмөр, Б.Гантулга
3	Анхан шатны бүрдэл дутуу 19.9 сая төгрөгийн баримтаар гүйлгээ хийсэн.	19.9	Зөвлөмж өгөх.			Дарга Нягтлан бодогч	Г.Гантөмөр, Б.Гантулга
4	Тусгай зориулалтын 1.7 сая төгрөгийн материалыг анхан шатны бүрдэл дутуу баримтаар зардалд бүртгэсэн.	1.7	Зөвлөмж өгөх.			Дарга Нягтлан бодогч	Г.Гантөмөр, Б.Гантулга
5	Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор 287.5 сая бараа материалын үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй.	287.5	Зөрчлийг арилгах албан шаардлага өгөх.			Дарга Нягтлан бодогч	Г.Гантөмөр, Б.Гантулга
6	Төсвийг зохистой удирдаагүйгээс шинээр 2.9 сая төгрөгийн авлага, 8.4 сая төгрөгийн өр, төлбөр үүсгэсэн.	11.3	Зөрчлийг арилгах албан шаардлага өгөх.			Дарга Нягтлан бодогч	Г.Гантөмөр, Б.Гантулга
7	Батлагдсан төсвийн 12.2 сая төгрөгийг зориулалтыг зөрчин зарцуулсан.	12.2	Зөрчлийг арилгах албан шаардлага өгөх.			Дарга Нягтлан бодогч	Г.Гантөмөр, Б.Гантулга
8	Төсвийг 0.4 сая төгрөгийн баримтгүйгээр зориулалт зөрчин зарцуулсан.	0.4	Төлбөрийн акт тогтоох			Дарга Нягтлан бодогч	Г.Гантөмөр, Б.Гантулга
9	Ажилтануудад цалинтай давхардуулан орчуулгын хөлс тооцож олгосон.	1.6	Зөрчлийг арилгах албан шаардлага өгөх.			Дарга Нягтлан бодогч	Г.Гантөмөр, Б.Гантулга
10	Ойн арга хэмжээнд зориулж 7.5 сая төгрөгөөр баримтат кино хийлгэж төсвийг үрэлгэн зарцуулсан.	7.5	Зөвлөмж өгөх.			Дарга Нягтлан бодогч	Г.Гантөмөр, Б.Гантулга
11	Шинээр худалдан авсан 26.4 сая төгрөгийн хөрөнгийг шууд зардлаар бүртгэсэн.	26.4	Зөвлөмж өгөх.			Дарга Нягтлан бодогч	Г.Гантөмөр, Б.Гантулга
12	Сангийн сайдын баталсан журам, зааварт нийцсэн санхүүгийн тайлан, тодруулга, журнал, бусад мэдээллийг ирүүлээгүй.	-	Зөвлөмж өгөх.			Дарга Нягтлан бодогч	Г.Гантөмөр, Б.Гантулга
	Нийт	399.6					



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.